

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2015 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Д.Сумъяабазар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2015 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаараа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв.

Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, Л.Эрдэнэчимэг нараас “Төсвийн хөрөнгөөр байгууллагын дотоод орчинд утаат тамхи татах цэгийг байгуулахгүй байх” гэсэн санал гаргасан тул Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.2.3-т заасны дагуу санал хураалгалаа.

Уг саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжээгүй болно.


Хуулийн төсөлд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр гишүүдийн олонхын дэмжлэг авсан саналуудыг тусгаж, техникийн болон найруулгын чанартай зарим засварыг хийлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл болон танилцуулгыг Та бүхэнд тараасан тул хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ